

**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ГУРВАНСАЙХАН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ЗАЙНААС ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН**

2021.10.25

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн Өмнөговь аймаг дахь Гурвансайхан нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 23/21 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг зайны аудитын хэлбэрээр хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ын ахлах аудитор Л.Жаргалсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ж.Нямдэлгэр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Өмнөговь аймаг дахь Гурвансайхан нисэх буудлын 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, нисэх буудлын даргын гаргасан тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, хүний нөөц бүрдүүлэлт, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлт, худалдан авалт, цалин хөлсний бодолт, олголт болон бусад үйл ажиллагаа зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Өмнөговь аймаг дахь Гурвансайхан нисэх буудлын 2020 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн аудитын шалгалтаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

Албан бичиг хэргийн хөтлөлт үг, үсэг, утга найруулгын алдаатай, албан бичгийн хаяг, тэргүүг стандартын дагуу хийгээгүй зөрчил давтагдан гарсаар байна.

Тушаалын төсөл боловсруулахдаа “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллаагүй байгаа нь бичиг хэрэг хариуцсан ажилтан заавар, журмаа уншиж судлаагүй, мэдлэггүй байгаатай холбоотой байна.

Иргэний нисэхийн үндэсний төвийн зүгээс орон нутгийн Нисэх буудлуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, үнэлэх журмыг хэрэгжүүлэх талаар нэгдсэн чиглэл өгч, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, төлөвлөгөөг батлаагүй, 2020 он, 2021 оны эхний хагас жилийн байдлаарх гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хянаагүй, үнэлээгүй байна.

Бараа материалыг бүртгэлд тусгахдаа барааны бүлгийг буруу бүртгэдэг байна.

Зэргийн нэмэгдлийн хугацаа дууссан байхад 1 нислэгийн удирдагчид нийт 1,298,846 төгрөгийн нэмэгдэл илүү олгосон байгаа нь журам, заавраа уншиж судлаагүй, мэддэггүйтэй холбоотой байна.

Ээлжийн амралтаа бүрэн эдлээгүй 1-4 хоногийн өмнө ажилдаа эргэн орсон 4 ажилтны ажилласан хугацаанд нь цалин бодож олгосноос ээлжийн амралт, цалин давхацсан байна.

Илүү цагийн тооцоог ИНҮТ-өөр хянуулаагүй, зөвшөөрөл аваагүйгээр илүү цагийн хөлс олгосон. Илүү ажилласан цагийг биеэр эдлүүлээгүй, ажлын цагийг нэгтгэн тооцох журмыг мөрдөж ажилладаггүйгээс зохицуулалт хийх боломжийг ашиглаж чадаагүй.

Ээлжийн ажилчдын ажлын цагийг бүртгэдэггүй.

Гэрээний төсөл боловсруулах, гэрээ байгуулах, төлөөлөх, бүртгэх, хадгалах, хяналт тавих, дүгнэх үйл явц ЗГ-ын тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, ИНЕГ-ын даргын баталсан “Иргэний нисэхийн ерөнхий газарт гэрээ байгуулах журам”-ын дагуу явагдахгүй байна.

Хөрөнгө, мөнгө захиран зарцуулах агуулга бүхий гэрээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлж, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргах байтал цахим хуудсанд мэдээлээгүй, мэдэгдлийг гаргаагүй байна.

Шилэн дансны мэдээллийг цахим системд буруу, дутуу оруулдаг дутагдал давтагдан гарсаар байна. Энэ нь ажил хариуцсан ажилтны хайнга байдал, шилэн дансны тухай хууль, журмын талаарх мэдлэг хангалтгүй байгаатай шууд холбоотой байна.

2021 онд шатахуун худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Худалдан авах ажиллагааны журмыг буруу сонгосон.

Худалдан авах төлөвлөгөөг тооцоо, судалгаагүй, үндэслэлгүй төсөвлөж төлөвлөлтийн шатанд алдаа гаргасан байна.

Төрийн худалдан авах цахим системд бүртгэлтэй болж худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах боломжтой болсон хэдий ч худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн ажилтны тоо хангалтгүй, тендер зохион байгуулах туршлага байхгүй.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын зааварчилгаа хангалтгүй, шат шатны хяналт, шалгалт шаардлагын түвшинд хүрээгүй байна.

Дотоод хяналтын баг нь үзлэг шалгалт хийхдээ удирдамж батлуулдаггүй, шалгалтын тайлан бичдэггүй, нэгжийн бүх үйл ажиллагааг хамруулж шалгалтыг хийдэггүй, зөвхөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг хэдий ч хангалттай түвшинд байж чадаагүй.

Дотоод хяналт хариуцсан ажилтны дотоод хяналтын талаарх ойлголт, мэдлэг тааруу, журам, заавраа уншиж судлах, өөрийгөө дайчлах шаардлагатай байна.

Өмнөх аудитын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал давтагдан гарсаар байгаа ба ажилд ахиц дэвшил гараагүй, зөвлөмжийн хэрэгжилт маш хангалтгүй түвшинд байна. Энэ нь ажил хариуцсан ажилтны мэдлэггүй, хариуцлагагүй байдалтай шууд холбоотой байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус нисэх буудалд 24 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА